

## ШАДАВЫН ЛУВСАНВАНДАНЫ НАМТРЫН ХУРААНГҮЙ



Овог: Бэсүд  
Нэр: Шадавын ЛУВСАНВАНДАН  
Төрсөн он, сар, өдөр: 1910 оны 1 сарын 20  
Төрсөн газар: Баянхонгор аймгийн Өлзийт сумын "Хашаат"

Нас барсан он, сар, өдөр: 1983 оны VII сарын 03

1925: Цэцэрлэгмандал аймгийн Баянзүрх уулын хошууны тамгын газарт тал бичээч болжээ.

1927: Улаанбаатар хотын нэгдүгээр дунд сургуульд оржээ.

1929: Улаан-Үд хотын багшийн техникумд суралцжээ.

1930: Улаанбаатар хотын Улгэр жишээ дунд сургуулийн багш болжээ.

1933: Улаан-Үд хотын монгол рабфакт монгол хэлний багш болжээ.

1935: Ардыг гэгээрүүлэх яамны хэвлэлийн тасагт хянан тохиолдуулагч болжээ.

1936: ШУХ-ийн Дуун ухааны тасгийн эрхлэгчээр томилогджээ.

1938: "Шинэ толь" сэтгүүлийн редакцийн зөвлөлийн гишүүн болжээ.

1941: Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон хүртжээ.

1943: МАХН-ын төв Төв хорооны сургуулийн тасгийн эрхлэгч болжээ.

1945: ШУХ-ийн Эрдэмтэн нарийн бичгийн даргаар томилогджээ.

1945: МУИС-д монгол хэлний багш болжээ.

1947: Монголын зохиолчдын хорооны дарга болжээ.

1949: МУИС-ийн Монгол хэлний тэнхимийн эрхлэгчээр томилогджээ.

1952: Сүхбаатарын одон хүртжээ.

1956: Профессор цол хүртжээ.

1958: Бээжингийн их сургуулийн монгол хэлний мэргэжилтэн багш болжээ.

1961: Монгол улсын ШУА-ийн жинхэнэ гишүүнээр сонгогддээ.

1970: Сүхбаатарын одон хүртжээ.

1971: "Орчин цагийн монгол хэлний бүтэц" хэмээх хоёр боть судалгааны бүтээл туурвисны учир Монгол улсын Төрийн шагнал хүртжээ.

1972: Хэл бичгийн шинжлэх ухааны доктор (Sc.D)-ын зэрэг хүртээжээ.

1980: Монгол улсын Гавьяат багш цол хүртжээ.